



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 451

Улаанбаатар хот

Г Дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах, Г
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2013 оны 154 дүгээр тогтоолын 2 ба 3 дахь заалт, “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн 5.2, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн салбарын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн нэгдүгээр, тус хөтөлбөрийг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайланг үйл ажиллагаа бүрээр гаргаж, улирал бүрийн гуравдахь сарын 25-ны дотор эрүүл мэндийн салбарын дэд зөвлөлд ирүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн салбарын дэд зөвлөл байгуулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 295 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

002914

2
Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 сарын 27-өдрийн 451 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

“Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг
хэрэгжүүлэх салбарын дэд зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга

Ж.Амарсанаа, Эрүүл мэндийн дэд сайд

Дэд дарга

А.Эрдэнэтуяа, ЭМЯ-ны Төрийн нарийн
бичгийн дарга;

Гишүүд:

Д.Оюунчимэг, ЭМЯ-ны Төрийн
захиргааны удирдлагын газрын дарга;

Ц.Цолмонгэрэл, Бодлого, төлөвлөлтийн
газрын дарга;

Б.Баярт, ЭМЯ-ны Төрийн захиргааны
удирдлагын газрын Хүний нөөцийн
хөгжлийн хэлтсийн дарга;

Д.Оюунцэцэг, ЭМЯ-ны Байгууллагын
удирдлага, хөгжлийн хэлтсийн дарга

Я.Буянжаргал, ЭМЯ-ны Бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

Ч.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн
төвийн дарга;

Б.Мягмар, Монголын эрүүл мэндийн
ажилтны үйлдвэрчний эвлэлийн
холбооны дарга;

Нарийн бичгийн дарга

Б.Сонинхүү, ЭМЯ-ны Бодлого,
төлөвлөлтийн газрын Салбар
хоорондын хамтын ажиллагаа, төр,
хувийн хэвшлийн түншлэлийн бодлого,
төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 сарын 17 өдрийн 457 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**“АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2013-2016)**

№	Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хяналт тавих хүн	
		Хөрөнгийн эх үүсвэр (төг)	Хугацаа (оноор)				
ЗОРИЛТ I. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлнэ.							
1.1	Эрүүл мэндийн салбарын бүтээн байгуулалт, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд шинээр бий болох ажлын байр, холбогдох хүний нөөцийн хэрэгцээ, байршуулалтын төлөвлөлт, сургалтын хэрэгцээг гаргаж, хэрэгжүүлнэ	Улсын төсөв	2013-2016	Эрүүл салбарт шинээр бий болгох ажлын байрнуудын хүний нөөцийн болон сургалтын хэрэгцээ хангагдсан байна.	БХЗГ, ТЗУГ	БТГ, аймаг, нийслэлийн ЭМГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунчимэг
1.2	Эрүүл мэндийн салбарын бүтээн байгуулалт, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд шинээр бий болгосон ажлын байрны тоо, ажлын байраар хангагдсан хүмүүсийн тоо, цалингийн төсвийн өсөлт, шаардлагатай сургалтын үр дүнгийн талаарх мэдээллийн сан бий болгоно	-	2013	Шинээр бий болгосон болон ажлын байранд байршуулсан хүний нөөцийн тоо, сургалтын үр дүнгийн талаарх мэдээллийн сан бий болно.	ЭМХТ	БХЗГ, ТЗУГ, аймаг, нийслэлийн ЭМГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунчимэг
1.3	Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох хүрээнд шинээр бий болсон ажлын байр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын ажил олгогчийн талаарх мэдээллийн сан бий болгоно	Улсын төсөв	2015	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын (шинээр бий болгосон) ажлын байрны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл гарна	БТГ, БХЗГ	ХШУДАГ, аймаг, нийслэлийн ЭМГ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Ц.Цолмонгэрэл
ЗОРИЛТ II. Жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчдыг зээл санхүүгийн							

үйлчилгээгээр дэмжинэ.							Ц.Цолмонгэрэл
2.1	Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эздэд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон бусад эх үүсвэрээс зээл авахад бодлогын дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлнэ	-	2014-2016	Дэмжлэгт орчин бүрдсэн байна.	БТГ, БХЗГ	СЗХ, МХХЭМБНХ	
ЗОРИЛТ III. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжил, ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн судалгааг үндэслэн ажил олгогчийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.							
3.1	Эрүүл мэндийн чиглэлээр эзэмшүүлэх мэргэжлийн индексийг салбарын ажил, мэргэжлийн ангилалтай уялдуулан шинэчлэнэ	2014		Мэргэжлийн индекс шинэчлэгдэн батлагдана	ТЗУГ	БШУЯ, ЭМХТ	Д.Оюунчимэг
3.2	Резидент эмч нарын сурах орчин нөхцлийг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	2015		Резидент эмч нарын сурах таатай нөхцөл бүрдсэн байна.	ТЗУГ, БХЗГ, ЭМХТ	БТГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунчимэг
3.3	Төгсөлтийн дараах богино хугацааны сургалтаар туслах сувилагч болон гэрийн асрагч сургаж, байршуулах ажлыг зохион байгуулна	2014-2016	Улсын төсөв	Туслах сувилагч, гэрийн асрагч бэлтгэх сургалт зохион байгуулагдаж, ажлын байраар хангагдсан байна.	ЭМХТ	ТЗУГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунчимэг
3.4	ДЭМБ-аас гаргасан "Хүний нөөцийн хэрэгцээг ажлын ачааллаар тооцох" аргачилалыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тооцно	ДЭМБ	2014-2015	Аргачилалыг нэвтрүүлж, үр дүнг тооцсон байна.	ТЗУГ, ЭМХТ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунчимэг
3.5	Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу шаардлагатай хүний нөөцийг үе шаттайгаар байршуулах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ	улсын төсөв	2015	Сандартын дагуу шаардлагатай хүний нөөцийг үе шаттайгаар байршуулсан байна.	ТЗУГ, ЭМХТ	БХЗГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунчимэг
ЗОРИЛТ IV. Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардагдах мэргэжилтэй ажилтныг урт болон богино хугацаагаар сургаж, мэргэшүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарын хэрэгцээг үндэсний ажиллах хүчээр хангана.							

4.1	2013-2016 онд эрүүл мэндийн ажилтанг гадаадын өндөр хөгжилтэй орны сургалтанд дагуу хамруулах тэргүүлэх чиглэлийн дагуу сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төрийн сангийн болон Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилт болон бусад эх үүсвэр	2013-2016	Сургалтын төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн ажилтнууд сургалтад хамрагдсан байна.	ЭМХТ	бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Ч.Бат-Эрдэнэ
4.2	Өндөр хөгжилтэй орны сургалтанд захиалгын дагуу хамрагдах хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийг хамруулахад дэмжлэг үзүүлэх	хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын төсөв	2014-2016	Өндөр хөгжилтэй орны мэргэшүүлэх сургалтанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц хамрагдсан байна.	ЭМХТ, МХХЭМБНХ	хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Ч.Бат-Эрдэнэ
ЗОРИЛТ V. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын идэвхи, санаачлагыг дэмжинэ.							
5.1	Эрүүл мэндийн салбарын хамтын хэлэлцээр, байгууллагын хамтын гэрээ, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан хяналт хийж, санал, зөвлөмж гаргана	Улсын төсөв	2013-2016	Салбарын хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн харилцаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах санал зөвлөмж гарсан байна.	БТГ, ТЗУГ, МЭМАУЭХ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн үйлдвэрчний эвлэлийн анхан шатны хороо	Ц.Цолмонгэрэл
5.2	Эрүүл мэндийн салбарт хамтын болон тарифын хэлэлцээрийг байгуулах талаар олон улсын туршлагыг судалж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргана	Эрүүл мэндийг дэмжих сан	2014	Олон улсын туршлагаас судалж, үр дүнг нэвтрүүлсэн байна.	БТГ, МЭМАУЭХ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн үйлдвэрчний эвлэлийн анхан шатны хороо	Ц.Цолмонгэрэл
5.3	"Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого"-ыг хэрэгжүүлж, төрийн зарим үйлчилгээг	Улсын төсөв	2013-2016	Бодлого хэрэгжиж, төрийн үйлчилгээг хувийн	БТГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Ц.Цолмонгэрэл

	гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хүрээг өргөжүүлнэ			хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хүрээ өргөжинө.				
ЗОРИЛТ VI. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, иргэн оршин суугаа газраасаа харьяалал үл харгалзан хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлнэ								
6.1	Эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн ангилалыг баталж, Үндэсний ажил мэргэжлийн ангилалд оруулах саналыг Хөдөлмөрийн яаманд хүргүүлнэ	-	2013-2014	Эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн ангилалыг үндэсний мэргэжлийн ангилалд оруулахаар ХЯ-д хүргүүлсэн байна.	ТЗУГ	ТЗУГ, ХЯ	Д.Оюунчимэг	
6.2	Эрүүл мэндийн салбарын ажил мэргэжлийн ангилалыг үндэслэн Эрүүл мэндийн статистик мэдээний маягтыг шинэчлэнэ	-	2013-2014	Эрүүл мэндийн статистик мэдээний маягт шинэчлэгдсэн байна.	ХШУДАГ	ТЗУГ	С.Төгсдэлгэр	
ЗОРИЛТ VII. Цалин хөлсний бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар ажиллагчдын бүтээмж, ур чадварыг урашуулан хөдөлмөрлөх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.								
7.1	Эрүүл мэндийн салбарын ажлын ачаалал, хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох судалгааны ажлыг дуусгаж, үр дүнг тооцно	Эрүүл мэндийг дэмжих сан	2014	Эрүүл мэндийн салбарын ажлын ачаалал, хөдөлмөрийн норм, норматив тогтоогож, үр дүнг тооцсон байна.	ТЗУГ, ХНУХХ	ЭМХТ, ЭМШУИС	Д.Оюунчимэг	
ЗОРИЛТ VIII. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан боловсронгуй болгоно.								
8.1	Эдийн засгийн салбарт хэрэгцээтэй байгаа ажиллах хүчийг гадаадаас авахад тавигдах мэргэжил, боловсрол, эрүүл мэндийн шалгуурыг боловсронгуй болгоно.	-	2013	Эдийн засгийн салбарт хэрэгцээтэй байгаа ажиллах хүчийг гадаадаас авахад тавигдах эрүүл мэндийн шалгуурыг боловсронгуй болох эрх зүйн	БХЗГ	НЭМХ	Я.Буянжаргал	

ЗОРИЛТ IX. Нийтийн эрх ашгийг хангах, ногоон хөгжлийн үйл ажиллагаанд ажилгүй иргэн, хөдөлмөрлөх боломжтой хүн амьг хамруулан орлогоор дэмжинэ.		орчин бүрдэнэ		орчин бүрдэнэ		орчин бүрдэнэ	
9.1	Хөгжиж буй орон нутгийн хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулж, шаардлагатай ажлын байранд нутгийн иргэдийг ажиллах саналыг дэмжинэ	Улсын төсөв	2014-2016	шинээр бий болсон ажлын байранд нутгийн иргэдийг ажиллуулах дэмжлэг бий болно.	БТГ	ТЗУГ, орон засаг захиргааны байгууллага	БХЗГ, нутгийн засаг захиргааны байгууллага
9.2	Эрүүл мэндийн байгууллагын гадаад орчныг ногоон орчин болгоход хэрэгцээт ажилтныг гэрээгээр ажиллуулах арга хэмжээг зохион байгуулна	улсын төсөв	2014-2016	Эрүүл мэндийн байгууллагын гадаад орчныг ногоон болгоход хэрэгцээт ажилтныг гэрээгээр ажиллуулсан байна.	ЭМХТ, ТЗУГ, ЭМБУХХ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Д.Оюунцэцэг